



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/40

Хэрлэн сум

Жишиг гудамжны 67 айлын  
хаус хорооллын төслийг хэрэгжүүлэх ажлын  
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жишиг гудамжны 67 айлын хаус хорооллын төслийн хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомж, журам заавар, стандарт, норм дүрмийн дагуу зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Нарийн бичгийн  
дарга:

Аймгийн ерөнхий архитектор

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, орон сууц, газрын харилцааны бодлого хариуцсан мэргэжилтэн

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч  
Хэнтий цахилгаан түгээх сүлжээ салбарын захирал  
“Хэнтий Ус ХХК”-ийн гүйцэтгэх захирал

2.Төслийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, улирал бүр үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ

D:\My Documents\Захирамж-2025

231010122

